

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН
Я.ШАРАВДОРЖИЙН НЭРЭМЖИТ ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А-38

Мөрөн

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 131 дүгээр зүйлийн 131.1.2, “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний технологийн сахилгын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.б дэх заалт, Салбарын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.1.2.5 дахь заалт зэргийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ.


1. Ус судлалын өртөөний ахлах техникч Намжий овогтой Лхагвасүрэн нь “Сануулах” арга хэмжээ авагдах зөрчил давтан гаргасан тул дахин зөрчил гаргавал ажлаас халахыг анхааруулж, хөдөлмөрийн хөлсийг 2 сарын турш 20%-иар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. 2017 оны 12 дугаар сарын 01-нээс эхлэн Н.Лхагвасүрэнгийн үндсэн цалингаас 2 сарын хугацаанд 20%-иар суутгал хийхийг нягтлан бодогч/ Н.Эрдэнэцэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Н.Лхагвасүрэнгийн ажилд дахин зөрчил гаргуулахгүй, ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийн биелэлтэнд байнга хяналт тавьж ажиллахыг Цаг уур, орчны технологийн хэлтэс/Б.Өнөрбат/-т үүрэг болгосугай.

4. Цаашид нийт ажилтан, албан хаагчдыг Төрийн албан хаагчийн ёс зүй, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний технологийн сахилгын дүрмийг мөрдөн ажилдаа хариуцлагатай хандаж ажиллахыг анхааруулсугай.

ДАРГА



А.ҮНЭНБАЯР

